



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА  
АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ



# БИЗНЕС ИТГЭЛИЙН ИНДЕКС 2020

СУДАЛГААНЫ ТАЙЛАН



The Project is funded  
by the European Union

Төслийг санхүүжүүлэгч Европын Холбоо

БИЗНЕС ИТГЭЛИЙН ИНДЕКС

© МҮХАҮТ 2021. “Бизнес итгэлийн индекс 2020” судалгааны зохиогчийн албан ёсны эрхийг МҮХАҮТ эзэмшинэ. Энэхүү мэдээллийг цааш түгээж байгаа бол зохиогчийн нэр болон эх сурвалжийг заавал дурдана уу.

## ӨМНӨХ ҮГ

Бизнесийн орчныг тогтмол анхааралтай ажиглаж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр бодлого шийдвэр, зохих арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлэх нь бизнес эрхлэх таатай тогтвортой орчинг бүрдүүлэхэд маш чухал билээ. МҮХАҮТ нь сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд бизнесийн орчинтой холбоотой судалгаануудыг тогтмол явуулж, судалгааны дүнд гарсан санал зөвлөмжийг бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарт хүргэж ирсэн.

МҮХАҮТ-аас 2001 оноос эхлэн явуулж байгаа “Бизнес итгэлийн индекс” судалгаагаар бизнесийн орчны ерөнхий төлөв байдал, хөрөнгө оруулалтын орчин, аж ахуйн нэгжүүдийн бизнесийн үйл ажиллагаа (ашиг, орлого), хөрөнгө оруулалт, макро эдийн засгийн үндсэн асуудлууд болох ядуурал, ажилгүйдэл, инфляцын талаар бизнес эрхлэгчдийн тухайн жилийн өөрчлөлтийн үнэлгээ, ирэх жилийн хүлээлтийг тооцдог.

“Бизнес итгэлийн индекс 2020” судалгааг Улаанбаатар хот, орон нутагт явуулж, 1400 гаруй аж ахуйн нэгжийг хамрууллаа. Энэ судалгаанд идэвхтэй оролцсон гишүүн байгууллагууд, аж ахуйн нэгжүүд судалгааг явуулахад хамтарч оролцсон аймаг дах Худалдаа аж үйлдвэрийн танхимүүд, Мэргэжлийн холбоодод МҮХАҮТ-ын зүгээс талархал илэрхийлж байна.

МҮХАҮТ энэхүү судалгааны тайланг Улсын Их Хурал, Монгол улсын Засгийн газар, яамдууд, төрийн байгууллагуудад хүргэх бөгөөд цаашид бизнесийн орчныг сайжруулах чиглэлд төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, бодлогын өмгөөлөл, нөлөөллийн үйл ажиллагааг эрчимжүүлэхэд илүү анхааран ажиллах болно.

Эдийн засаг бизнесийн орчинд бизнес эрхлэгчдийн өгч байгаа үнэлгээ, цаашдын хүлээлтийг тодорхойлсон энэхүү “Бизнесийн итгэлийн индекс” судалгааны тайлан нь бизнесийн орчны индикатор болохын хувьд Та бүхний мэдээллийн чухал нэг эх үүсвэр болно гэдэгт итгэлтэй байна.

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

## АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ .....	3
ХУРААНГУЙ .....	5
I. Бизнес итгэлийн индекс .....	6
1.1. Бизнесийн орчны үнэлгээ, хүлээлт .....	8
1.2. Хөрөнгө оруулалтын орчин .....	10
1.3. Ажил эрхлэлт, үнийн өсөлт, ядуурал .....	12
1.4. Бизнесийн үйл ажиллагаа .....	14
II. Бизнес тугамдаж буй гол асуудлууд .....	25
III. Судалгааны арга зүй, оролцогчдын мэдээлэл .....	27

## ХУРААНГУЙ

2020 оны Бизнес итгэлийн индекс судалгаа нь дэлхий дахинд цар тахлын нөлөөгөөр гадаад болон дотоод орчны тодорхойгүй байдал нэмэгдсэн, аж ахуйн нэгж, өрхийн орлого буурсан, хэрэглэгчдийн худалдан авах зан төлөвт өөрчлөлт орж илүү хадгалах хандлагатай болсноор дотоод эрэлт буурсан, гадаад зэх зээлд түүхий эдийн эрэлт, тээвэр худалдааны нөхцөл муудсан зэргээс шалтгаалан эдийн засаг, бизнесийн орчин тодорхойгүй, илүү муудсан жилд хийгдсэнээрээ онцлог байлаа. Судалгаанд Улаанбаатар хот, орон нутгийн нийт 1456 аж ахуйн нэгжийг хамруулан үр дүнг нэгтгэв.

Мөн онцлог нь бизнесийн итгэлийн өөрчлөлтийг эдийн засгийн гол салбаруудаар нарийвчлан үнэлэх зорилгоор олон улсын туршлагаар судалгааны аргачлалыг шинэчлэн боловсруулж, үр дүнг нэгтгэн танилцуулж байна. Судалгаанд бизнесийн ерөнхий орчин, бизнесийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын орчин, макро үзүүлэлт гэсэн үндсэн 4 хэсгийн нийт 12 үзүүлэлтүүдэд тулгуурлан индексийг тооцсон.

2020 оны Бизнес итгэлийн индекс -0.28 үнэлгээтэй гарсан ба өмнөх оны үнэлгээнээс 0.35 функтээр буурсан дүн байна. 2020 оны бизнес итгэлийн индексийн үнэлгээ нь гадаад худалдааны нөхцөл муудсан, хөрөнгө оруулалт агшсан 2015 оны индекстэй ойролцоо үнэлгээтэй байна. Бизнес итгэлийн индексийг тооцдог үзүүлэлтүүдээр нарийвчлан авч үзвэл бизнесийн орчны үнэлгээ, бизнесийн үйл ажиллагаатай холбогдох дэд үзүүлэлтүүд хамгийн бага үнэлгээ авсан. Эдийн засгийн гол салбаруудаар авч үзвэл барилга, үйлчилгээ, худалдааны салбаруудын итгэлийн индекс хамгийн бага үнэлгээтэй байгаа бол үйл ажиллагаа явуулж буй байршлаар авч үзвэл Улаанбаатар хотын бизнес эрхлэгчид улсын дунджаас бага үнэлгээ өгчээ.

2016 оноос эхлэн бизнесийн орчин өмнөх оноос хэрхэн өөрчлөгдсөн тухай үнэлгээ тогтмол сайжирч байсан бол 2020 онд 0.5 пунктээр буурч -0.43 үнэлгээтэй гарсан. Судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 43 хувь нь 2021 онд бизнесийн орчин илүү сайжирна гэж таамаглаж байна. 2020 онд хөрөнгө оруулалтын орчны индекс -0.03 үнэлгээтэй гарсан ба энэ нь өмнөх оноос 0.23 пунктээр буурсан дүнтэй байгаа ба хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулалт хамгийн бага хийгдсэн байна. 2020 оныг хөрөнгө оруулалт хийхэд тааламжгүй хэмээн үзэж сүүлийн 5 жилийн хамгийн бага үнэлгээтэй байсан бол 2021 онд хөрөнгө оруулалт хийх тухай хүлээлт 11 пунктээр өссөн, хүлээлт эргэн сэргэсэн үзүүлэлттэй байна.

2020 онд судалгааны аргачлалыг шинэчлэхдээ бизнесийн үйл ажиллагааны дэд үнэлгээнд үйл ажиллагаанд нөлөөлөх үзүүлэлтүүдийг нэмж тооцсон ба бизнесийн үйл ажиллагааны индекс-0.42 үнэлгээтэй гарсан. Үйлдвэрлэл, барилгын салбарын бизнес эрхлэгчид бизнесийн үйл ажиллагаанд илүү хүндрэлтэй байна гэж үзэж, хамгийн бага үнэлгээ өгсөн. Бизнесээ өргөжүүлэхэд санхүүгийн нөхцөл байдал, бараа бүтээгдэхүүний эрэлтийн бууралт хамгийн сөрөг нөлөөтэй байна гэжээ

Бизнесийн орчинд нэн тэргүүнд шийдвэрлэх асуудлыг сүүлийн 4 жилээр нэгтгэн авч үзвэл “Зээлийн өндөр хүү, хугацаа” гэсэн асуудлыг дараалан хамгийн тулгамдаж буй асуудлаар нэрлэсэн байна. Түүнчлэн бизнестэй холбогдох “Бодлогын тогтворгүй байдал” нь бизнесийн орчинг сайжруулахад нэн тэргүүнд шийдвэрлэх хэрэгтэй асуудал гэжээ.

## I. Бизнес итгэлийн индекс

Бизнесийн ерөнхий орчин, бизнесийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын орчин, макро үзүүлэлт гэсэн гол 4 бүрэлдэхүүн хэсгийн нийт 12 үзүүлэлтүүдэд тулгуурлан бизнес итгэлийн индексийг тооцсон. 2020 оны Бизнес итгэлийн индекс судалгааг OECD, Европын холбооны улсуудын туршлага судлан, эдийн засгийн гол салбаруудаар тооцох аргачлалыг шинэчлэн боловсруулсан.

2020 оны Бизнес итгэлийн индекс -0.28 үнэлгээтэй гарсан нь өмнөх оны үнэлгээнээс 0.35 функтээр буурсан ба гадаад худалдааны нөхцөл муудсан, хөрөнгө оруулалт агшсан 2015 оны индекстэй ойролцоо үнэлгээтэй байна. (Зураг 1)

Зураг 1. Бизнес итгэлийн индекс (2012-2020), шинэчилсэн аргачлалаар тооцсон



Бизнес итгэлийн индексийг тооцдог үзүүлэлтүүдээр нарийвчлан авч үзвэл бизнесийн орчны ерөнхий үнэлгээ, бизнесийн үйл ажиллагааны үнэлгээний дэд үзүүлэлтүүд хамгийн бага үнэлгээ авсан. Хөрөнгө оруулалтын индекстэй холбогдох үзүүлэлт бусад дэд үзүүлэлтүүдээс сайн талдаа үнэлэгдсэн боловч -0.03 үнэлгээтэй байна. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. 2020 оны Бизнес итгэлийн индекс, дэд үзүүлэлтүүдээр

	Үзүүлэл	Индекс
<b>1</b>	<b>Бизнесийн орчны ерөнхий үнэлгээний индекс</b>	<b>(0.43)</b>
<b>2</b>	<b>Бизнесийн үйл ажиллагааны үнэлгээний индекс</b>	<b>(0.42)</b>
2.1	Үйлдвэрлэлийн хэмжээний өөрчлөлт (бизнесийн үйл ажиллагааны хэмжээ)	(0.39)
2.2	Бараа бүтээгдэхүүний эрэлтийн өөрчлөлт (захиагын хэмжээ)	(0.46)
2.3	Борлуулалтын орлогын өөрчлөлт	(0.29)
2.4	Санхүүгийн үзүүлэлт	(0.55)
<b>3</b>	<b>Хөрөнгө оруулалтын орчны үнэлгээний индекс</b>	<b>(0.03)</b>
<b>4</b>	<b>Макро үзүүлэлтүүдийн өөрчлөлтийн индекс</b>	<b>(0.26)</b>
4.1	Ажиллагсдын тоо	(0.24)
4.2	Бараа бүтээгдэхүүний дундаж үнэ	(0.21)
4.3	Ядуурлын түвшин	(0.32)
	<b>БИЗНЕС ИТГЭЛИЙН ИНДЕКС</b>	<b>0.28)</b>

Дэд үзүүлэлтүүдийн сүүлийн 3 жилийн үнэлгээг харьцуулан авч үзвэл 2018-2019 онуудад Бизнесийн орчны өөрчлөлтийн үнэлгээ, бизнесийн үйл ажиллагааны үнэлгээ, хөрөнгө оруулалтын өөрчлөлтийн үзүүлэлтүүд эерэг үнэлгээтэй байсан бол 2020 онд бүгд сөрөг үнэлгээ авсан. Харин макро эдийн засгийн үзүүлэлтийн үнэлгээ нь 2018 оны үнэлгээтэй ойролцоо дүнтэй байна.

2020 онд дэд үзүүлэлтүүдээс бизнес эрхлэх ерөнхий орчин, бизнесийн үйл ажиллагаатай холбогдох үзүүлэлтүүд хамгийн ихээр муудсан гэж үзжээ. (Зураг 2)


Зураг 2. 2018-2020 оны Бизнес итгэлийн индекс, дэд үзүүлэлтүүдээр



Шинэчилсэн аргачлалаар бизнес итгэлийн индексийн үнэлгээг эдийн засгийн гол салбаруудаар ангилан авч үзвэл барилга, үйлчилгээ, худалдааны салбарын бизнес эрхлэгчдийн бизнесийн орчинд итгэх итгэл улсын дунджаас бага байна.

Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа явуулж байгаа байршлаар нь ангилан харвал Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг бизнес эрхлэгчид бизнесийн орчинд илүү бага үнэлгээ өгсөн байна. (Зураг 3)

Зураг 3. 2020 оны Бизнес итгэлийн индекс, эдийн засгийн гол салбаруудаар, байршлаар



### 1.1. Бизнесийн орчны үнэлгээ, хүлээлт

2020 онд цар тахлын улмаас шат дараалсан хөл хорио тогтоож, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа доголдсон нь аж ахуйн нэгжийн болон өрхийн орлого, эдийн засгийн идэвхжилд сөргөөр нөлөөлөв. Түүнчлэн гадаад болон дотоод орчны тодорхойгүй байдал нэмэгдсэнтэй холбоотойгоор хэрэглэгчдийн худалдан авах зан төлөвт өөрчлөлт орж илүү хадгалах хандлагатай болсноор дотоодод бараа, үйлчилгээний эрэлт буурсан зэрэг нь бизнест сөрөг нөлөөтэй байлаа.


МҮХАҮТ-ын 2020 оны 3 сарын цар тахлын бизнест үзүүлж буй нөлөөний судалгаагаар цар тахлын нөлөө үйлчилгээний салбарт (аялал, жуулчлал, агаарын тээвэр, зочид бүүдал, нийтийн хоолны салбар) илүү сөргөөр нөлөөлж байсан бол 2020 оны 11 сарын судалгаагаар бизнесийн бүх салбарт маш их нөлөөлсөн дүнтэй байна.

#### Бизнесийн орчны өөрчлөлтийн үнэлгээ

2020 оны Бизнесийн орчны өөрчлөлтийн индекс -0.43 үнэлгээтэй гарсан ба 2015, 2016 онуудын үнэлгээтэй ойролцоо дүн болж байна. 2015-2016 онд гадаад эрэлт, хөрөнгө оруулалт, хэрэглээ саарч, эдийн засгийн идэвхжил буурсан жилүүд байсан ба бизнесийн орчны өөрчлөлттэй холбогдох индекс -0.45, -0.46 үнэлгээ тус тус авч байсан юм. 2016 оноос эхлэн бизнесийн орчин өмнөх оноос хэрхэн яаж өөрчлөгдсөн тухай үнэлгээ тогтмол сайжирч байсан бол 2020 онд 0.5 пунктээр буурсан байна.

Эдийн засгийн гол салбаруудаар үнэлгээг авч үзвэл бүх салбарт сөрөг нөлөөтэй байсан тухай хариулсан ба үйлчилгээ, барилгын салбарт бизнес эрхлэх орчин өмнөх жилээс илүү ихээр муудсан гэжээ. (Зураг 4)

Зураг 4. Бизнесийн орчны өөрчлөлтийн индекс, салбараар






Бизнесийн орчны өөрчлөлтийн хүлээлт

Бизнес эрхлэгчдийн дараа жилийн бизнесийн орчинг хэрхэн төсөөлж, таамаглаж байгаа нь эдийн засаг, бизнесийн шийдвэрүүдэд чухал нөлөөтэй, холбогдох бодлого шийдвэр гаргахад анхаарах гол үзүүлэлтүүдийн нэг юм. Бизнес эрхлэгчид бизнесийн орчинг илүү өөдрөгөөр таамаглаж байгаа тохиолдолд бизнестээ ямар нэг хэмжээгээр хөрөнгө оруулалт хийх, шинээр ажлын байр бий болгох, богино хугацааны үйлдвэрлэл, үйл ажиллагаагаа нэмэгдүүлэх зэргээр эдийн засагт шууд болон шууд бус эерэг нөлөөтэй байдаг. Бизнес итгэлийн индекс судалгааны бизнесийн орчны талаарх бизнес эрхлэгчдийн хүлээлт нь тухайн жилийн эдийн засгийн өсөлттэй адил трендтэй байдаг.


2019 оны судалгаагаар судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 31 хувь нь 2020 онд бизнесийн орчин сайжирна гэсэн хүлээлттэй байсан бол 2020 оны бодит байдалд бизнес эрхлэгчдийн 18 хувь нь сайжирсан үнэлгээ өгчээ. Харин 2021 онд бизнесийн орчин сайжрах тухай бизнес эрхлэгчдийн хүлээлт өмнөх оноос 12 хувиар өсч 43 хувь болжээ. Мөн УИХ-ын сонгуультай жилүүдэд бизнес эрхлэгчдийн бизнесийн орчин сайжрах тухай хүлээлт бүүрсан дүнтэй байдаг байна. (Зураг 5)

Зураг 5. Бизнесийн орчны өөрчлөлтийн үнэлгээ, хүлээлт (2013-2021 он, эдийн засгийн өсөлт, сонгууль)



2021 онд бизнесийн ерөнхий орчин хэрхэн өөрчлөгдөх тухай хүлээлтийг эдийн засгийн гол салбаруудаар ангилан авч үзвэл үйлдвэрлэл, ХАА-н салбарууд илүү сайжрах хүлээлттэй байгаа бол барилга, худалдааны салбар бусад салбаруудтай харьцуулахад муудах тухай хүлээлттэй байна. (Зураг 6)

Зураг 6. 2021 онд бизнесийн орчин хэрхэн өөрчлөгдөх тухай хүлээлт, салбараар



**1.2. Хөрөнгө оруулалтын орчин**


Дэлхийн банкны 2020 оны тайланд өнөөгийн Монгол улсын уул уурхайгаас хэт хамаарсан эдийн засгийн загвар нь ирээдүйд тогтвортой өсөлт авчрах нь эргэлзээтэй ба өсөлтийн зогсонги байдалд оруулах эрсдэлтэй. Түүнчлэн дундаас дээш орлоготой, төрөлжсөн эдийн засгийн суурийг тавихын тулд өрсөлдөөнийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулах, бизнесээ өргөжүүлэх боломжийг олгох, эрх тэгш нөхцөлийг бүрдүүлэхийн тулд хөрөнгө оруулалтын орчинг эрс сайжруулах хэрэгтэй гэжээ. 2020 оны хөрөнгө оруулалтын статистик мэдээллийг авч үзвэл Монгол улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалт 2.5 тэрбум ам доллар болж өмнөх оноос 571 сая ам доллар ба 22 хувиар буурсан дүнтэй байна.

МҮХАҮТ-аас Бизнес итгэлийн индексийг тооцдог нэг гол үзүүлэлт нь хөрөнгө оруулалттай холбогдох үзүүлэлт байдаг бөгөөд энэхүү судалгааг авч эхэлсэн 2000 оноос эхлэн бизнес эрхлэгчид тухайн жилдээ бизнестээ ямар нэг хөрөнгө оруулалт хийсэн эсэх, ирэх жилд ямар нэгэн хөрөнгө оруулалт хийх хүлээлт байгаа эсэхийг тогтмол асуусан байдаг.

*Хөрөнгө оруулалтын орчны үнэлгээ*

2020 онд хөрөнгө оруулалтын орчны индекс -0.03 үнэлгээтэй гарсан ба энэ нь өмнөх оноос 0.23 пунктээр буурсан дүнтэй байна. Хөрөнгө оруулалтын орчинтой холбогдох үнэлгээ 2017 оноос хойш эерэг дүнтэй гараад байсан юм. Эдийн засгийн гол салбаруудаар авч үзвэл хөдөө аж ахуйн салбарт хамгийн бага үнэлгээг өгчээ. (Зураг 7)


*Зураг 7. Хөрөнгө оруулалтын орчны индекс, салбараар*



*Хөрөнгө оруулалтын орчны хүлээлт*

Судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдээс 2021 онд бизнестээ ямар нэг хөрөнгө оруулалт хийх тухайд тодруулахад 69 хувь нь хөрөнгө оруулалт хийх тухай эерэг хүлээлттэй байгаа ба өмнөх оноос 11 пунктээр өссөн дүнтэй байна. 2019 оны судалгаагаар 2020 оныг бизнес эрхлэгчид хөрөнгө оруулалт хийхэд тааламжгүй байна хэмээн таамаглан сүүлийн 5 жилийн хамгийн бага хүлээлттэй байсан бол 2021 онд энэхүү хүлээлт эргэн сэргэсэн үзүүлэлттэй байгаа юм. (Зураг 8).

*Зураг 8. 2021 онд бизнестээ хөрөнгө оруулалт хийх тухай хүлээлт*



### 1.3. Ажил эрхлэлт, үнийн өсөлт, ядуурал

Олон улсын валютын сангийн 2020 оны 10 дугаар сарын тайланд цар тахлын нөлөөгөөр эдийн засгийн хүндрэлтэй жилүүдэд хүндрэлийн нөлөө нь дундаж болон ядуурлын түвшингээс доогуур давхаргад илүү ихээр нөлөөлж, улмаар ядуурлын түвшин өссөн үзүүлэлттэй байгаа талаар дурдсан байна.

2020 оны Монгол улсын статистик мэдээллийг авч үзвэл эдийн засгийн идэвхжил буурснаар эрэлтийн нөлөөгөөр инфляцын түвшин 2.3 хувь ба нам дор түвшинд хадгалагдсан, албан тоогоор ажилгүйдлийн түвшний өөрчлөлт бага байж өмнөх улирлаас 0.3 хувиар өсч 7.6 хувь болсон боловч ажиллагсад эдийн засгийн идэвхгүй хүн амруу шилжсэн, бүртгэлгүй ажилгүйдлийн түвшин өссөн, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хүндхэн жил байлаа.


#### Өөрчлөлтийн үнэлгээ

2020 оны Бизнес итгэлийн Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 56 хувь нь ажилгүйдлийн түвшин өөрчлөгдөөгүй гэж үзсэн бол 33 хувь нь ажилгүйдэл өссөн гэж хариулжээ.

Бараа бүтээгдэхүүний үнэ хэрхэн өөрчлөгдсөн талаар тодруулахад судалгаанд оролцогсдын 45 хувь нь өөрчлөгдөөгүй гэж үзсэн бол 36 хувь нь бараа, бүтээгдэхүүний үнэ өссөн гэжээ.

Мөн бизнес эрхлэгчдийн 40 хувь нь ядуурлын түвшин өссөн, 36 хувь нь өөрчлөгдөөгүй гэж үзсэн бол 17 хувь нь хэлж мэдэхгүй байна гэсэн байна. (Зураг 9).

Зураг 9. Ажилгүйдэл, инфляц, ядуурлын түвшингийн 2020 оны өөрчлөлтийн үнэлгээ




2021 онд хэрхэн өөрчлөгдөх тухай хүлээлт

Цар тахлын халдвар хамгааллын хөл хорио тодорхой хэмжээнд суларсан 2021 оны 2-р улиралд ажилгүйдэл, бараа бүтээгдэхүүний үнэ, ядуурлын түвшин хэрхэн өөрчлөгдөх хүлээлттэй байгаа талаар тодрууллаа.


Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжийн 54 хувь нь ажилгүйдлийн түвшин өөрчлөгдөхгүй, 19 хувь нь буурна, 17 хувь нь ажилгүйдлийн түвшин өснө гэжээ. Бараа бүтээгдэхүүний үнэ хэрхэн өөрчлөгдөх тухайд 44 хувь нь өөрчлөгдөхгүй, 36 хувь нь өснө гэж таамаглаж байна. Харин ядуурлын түвшинг 34 хувь нь өөрчлөгдөхгүй, 31 хувь нь өснө, 22 хувь нь хэлж мэдэхгүй байна гэжээ. (Зураг 10).

Зураг 10. Ажилгүйдэл, инфляц, ядуурлын түвшин 2021 онд хэрхэн өөрчлөгдөх тухай хүлээлт



2021 оны 2-р улиралд ажиллагсдын тоо хэрхэн өөрчлөгдөх тухайд бизнес эрхлэгчдийн хүлээлтийг эдийн засгийн гол салбаруудаар ангилан харвал судалгаанд оролцсон барилгын салбарын бизнес эрхлэгчдийн 25 хувь, үйлдвэрлэлийн салбарын 19 хувь нь ажиллагсдын тоо буурна гэжээ. Харин хөдөө аж ахуйн салбарын бизнес эрхлэгчдийн 24 хувь нь ажиллагсдын тоо өснө гэж таамаглаж байна. Худалдаа, үйлчилгээний салбарын хувьд ажиллагсдын тооны өөрчлөлт харьцангуй тогтвортой байна гэж таамаглаж байна. (Зураг 11).

Зураг 11. 2021 оны 2-р улиралд ажиллагсдын тооны өөрчлөлтийн хүлээлт, салбараар




### 1.4. Бизнесийн үйл ажиллагаа

Бизнес итгэлийн индекс судалгааг энэ жилээс эхлэн олон улсын туршлага, Үндэсний статистикийн хорооны ДНБ тооцдог ангиллыг харгалзан үйлдвэрлэл, худалдаа, барилга, хөдөө аж ахуй, үйлчилгээ гэсэн үндсэн 5 салбараар үнэлгээг тооцож, салбар тус бүрээр бизнесийн үйл ажиллагаа явуулах нөхцөл байдлыг үнэлэх, тулгарч буй хүндрэлийг тодорхойллоо. Өмнөх жилүүдэд аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны үнэлгээг ашиг, орлогын түвшний өөрчлөлтөөр тооцдог байсан бол 2020 оноос (1)үйлдвэрлэл, үйл ажиллагааны хэмжээ, (2)бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт, (3)санхүүгийн нөхцөл байдал гэсэн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд чухал нөлөөтэй гурван үзүүлэлтүүдийг нэмж тооцох болсон.


2020 оны бизнесийн үйл ажиллагааны индекс -0.42 үнэлгээтэй гарсан ба эдийн засгийн гол салбаруудаар авч үзвэл үйлдвэрлэл, барилгын салбарын бизнес эрхлэгчид хамгийн бага үнэлгээг өгсөн байна. Бизнесийн үйл ажиллагаа явуулж буй байршлаар нь харвал Улаанбаатар хотын бизнес эрхлэгчид бизнесийн үйл ажиллагаа явуулахад илүү хүндрэлтэй байна гэжээ.

Харин борлуулалтын орлого хэрхэн өөрчлөгдсөн тухай тодруулахад судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн дөнгөж 25 хувь нь өссөн гэж хариулсан ба борлуулалтын орлогын өөрчлөлтийн эерэг үнэлгээ нь сүүлийн 3 жилд дунджаар 50 орчим хувьтай байсан юм. (Зураг 12).

Зураг 12. Бизнесийн үйл ажиллагааны индекс (салбараар), борлуулалтын орлогын өөрчлөлт



Үйлдвэрлэлийн салбарын үйл ажиллагааны үнэлгээ




Гол үзүүлэлт	2019 он	2020он	Өөрчлөлт	%
Үйлдвэрлэл (тэрбум.төг, 2010 з.үнэ)	5,699	5,352	-347	-6.1%
Ажиллагсдын тоо (мян.хүн)	181	160	-20.7	-11.5%
Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн тоо	8,186	7,271	-915	-11%

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд үндэслэн хийсэн судлаачийн тооцоолол

байгаа аж ахуйн нэгжийн 10 орчим хувь нь үйлдвэрлэлийн салбарт ба 2021 оны 1-р улирлын байдлаар нийт 7.3 мянга аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь өмнөх оноос 11 хувиар буурсан байна.


Бизнесийн үйл ажиллагааны дундаж индекс -0.42 байгаа бол үйлдвэрлэлийн салбарын бизнес эрхлэгчид -0.52 үнэлгээ өгсөн ба үйлдвэрлэлийн салбарын бизнес эрхлэгчдэд бизнесийн үйл ажиллагаа явуулахад хамгийн их хүндрэл тулгарч байна гэжээ. (Зураг 13)

Зураг 13. Бизнесийн үйл ажиллагааны индекс



Бизнесийн үйл ажиллагааны үнэлгээг тооцсон нарийвчилсан үзүүлэлтүүдээр харвал 2020 онд судалгаанд оролцсон үйлдвэрлэлийн салбарын бизнес эрхлэгчдийн 61 хувь нь үйлдвэрлэлийн хэмжээ буурсан бөгөөд одоогоор үйлдвэрлэлийн хүчин чадлын дөнгөж 55 хувийг ашиглаж байгаа, 64 хувь нь бараа бүтээгдэхүүний захиалга, эрэлтийн хэмжээ хэвийн түвшингээс бага байсан гэжээ. Мөн экспортын бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэрлэгчдийн хувьд 66 хувь нь экспортын барааны захиалга буурсан гэж хариулсан байна. Үйлдвэрлэлийн салбарын бизнес эрхлэгчдийн 55 хувь нь борлуулалтын орлогын хэмжээ буурсан, 63 хувь нь санхүүгийн нөхцөл байдал муу байна гэсэн байна. Санхүүгийн нөхцөл байдалд бусад салбаруудтай харьцуулахад үйлдвэрлэлийн салбарын бизнес эрхлэгчид хамгийн тааруухан үнэлгээ өгчээ. (Зураг 14)

Зураг 14. Бизнесийн үйл ажиллагааны нарийвчилсан үнэлгээ



Үйлдвэрлэлийн салбарын бизнес эрхлэгчдийн хувьд үйлдвэрлэлээ өргөжүүлэхэд тулгарч буй бэрхшээлийг тодруулахад давхардсан тоогоор 50 орчим хувь нь төлбөр гүйцэтгэх чадвар, зээлийн нөхцөл гэх мэт санхүүтэй холбогдох асуудал, 42 хувь нь дотоод эрэлтийн хэмжээ, 28 хувь нь бизнес эдийн засгийн орчинтой холбогдох ойлгомжгүй, уялдаа холбоогүй хууль тогтоомжууд хамгийн их хүндрэл үүсгэж байна гэжээ. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Үйлдвэрлэлээ өргөжүүлэхэд тулгарч буй бэрхшээл

Д/д	Тулгарч буй бэрхшээл	Хувь
1	Санхүүгийн асуудал (төлбөрийн чадваргүй байдал, зээлийн нөхцөл г.м)	50%
2	Дотоодын эрэлт	42%
3	Бизнес, эдийн засагтай холбогдох ойлгомжгүй, уялдаа холбоогүй хууль, тогтоомжууд	28%



Худалдааны салбарын үйл ажиллагааны үнэлгээ



Худалдааны салбарт бөөний болон жижиглэн худалдааны салбарыг нэгтгэн авч үзсэн. Худалдааны салбар нь ДНБ-ний 11 хувь, нийт ажиллах хүчний 15 хувийг эзэлдэг.

Үндэсний статистикийн хорооны статистик мэдээллийг авч үзвэл 2020 онд салбарын борлуулалт 2 их наяд төгрөг болж өмнөх оноос 11.1 хувиар буурсан. Харин нийт ажиллагсдын 15 хувь ба 166 мянган хүн худалдааны салбарт ажиллаж байна.

2021 оны 1-р улирлын байдлаар нийт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 48 хувь ба нийт 36 мянга аж ахуйн нэгж худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж

Гол үзүүлэлт	2019 он	2020он	Өөрчлөлт	%
Борлуулалт (тэрбум.төг, 2010 з.үнэ)	2,310	2,053	-257	-11.1%
Ажиллагсдын тоо (мян.хүн)	161	166	4.4	2.7%
Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн тоо	37,483	36,031	-1,452	-4%

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд үндэслэн хийсэн судлаачийн тооцоолол

байна. Энэ нь өмнөх оноос 4 хувиар буурсан байна.


Бизнес эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааны үнэлгээг эдийн засгийн салбараар ангилан авч үзвэл худалдааны салбарт -0.26 ба бусад салбаруудаас илүү эерэг талдаа үнэлгээ өгсөн байна. Бизнесийн үйл ажиллагааны дэд индекс -0.42-оор үнэлэгдсэн ба худалдаанаас бусад бүх салбарууд дундаж индексээс бага үнэлгээтэй байна. (Зураг 15)

Зураг 15. Бизнесийн үйл ажиллагааны индекс



Бизнесийн үйл ажиллагааны үнэлгээг тооцсон дэд үзүүлэлтүүдээр нарийвчлан харвал 2020 онд судалгаанд оролцсон худалдааны салбарын бизнес эрхлэгчдийн 58 хувь нь үйлдвэрлэлийн хэмжээ буурсан, 49 хувь нь бараа бүтээгдэхүүний захиалга, эрэлтийн хэмжээ хэвийн түвшингээс бага байсан гэжээ. Худалдааны салбарын бизнес эрхлэгчдийн 51 хувь нь борлуулалтын орлогын хэмжээ буурсан гэсэн бол 49 хувь нь санхүүгийн нөхцөл байдал муу байна гэсэн байна. (Зураг 16)

Зураг 16. Худалдааны салбарын үйл ажиллагааны нарийвчилсан үнэлгээ




Худалдааны салбарын бизнес эрхлэгчдийн хувьд үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд тулгарч буй хүндрэлийг тодруулахад давхардсан тоогоор 44 орчим хувь нь банкнаас зээл авах боломж, 40 хувь нь борлуулалтын хэмжээ хангалттай биш байдал гэсэн бол 37 хүүгийн зардал гэх мэт санхүүтэй холбогдох зардлууд хамгийн их хүндрэл үүсгэж байна гэжээ. (Хүснэгт 3)

Хүснэгт 3. Худалдааны салбарын бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд тулгарч буй бэрхшээл

Д/д	Тулгарч буй бэрхшээл	Хувь
1	Банкнаас зээл авах боломж	44%
2	Борлуулалтын хэмжээ хангалттай биш	40%
3	Санхүүгийн зардал (хүүгийн зардал гм.)	37%

Барилгын салбарын үйл ажиллагааны үнэлгээ



Барилгын салбар нь ДНБ-ийн 4 хувь, нийт ажиллагсдын 6 хувийг эзэлдэг.

Үндэсний статистикийн хорооны статистик мэдээллийг авч үзвэл 2020 онд салбарын үйлдвэрлэл 703 тэрбум төгрөг болж өмнөх оноос 7.4 хувиар, ажиллагсдын тоо 64.4 мянга болж өмнөх оноос 12.6 хувиар буурсан байна.


Гол үзүүлэлт	2019 он	2020он	Өөрчлөлт	%
Үйлдвэрлэл (тэрбум.төг, 2010 з.үнэ)	703.2	651.3	-51.9	-7.4%
Ажиллагсдын тоо (мян.хүн)	73.7	64.4	-9.3	-12.6%
Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн тоо	7,537	7,269	-268	-4%

2021 оны 1-р улирлын байдлаар нийт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 10 хувь ба нийт 7.3 мянга аж ахуйн нэгж барилгын салбарт үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь өмнөх оноос 4 хувиар буурсан дүн юм.

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд үндэслэн хийсэн судлаачийн тооцоолол


Бизнесийн үйл ажиллагааны үнэлгээг эдийн засгийн салбараар ангилан авч үзвэл барилгын салбарт -0.49 ба дундаж индексээс бага үнэлгээ өгсөн байна. (Зураг 17)

Зураг 17. Бизнесийн үйл ажиллагааны индекс



Бизнесийн үйл ажиллагааны үнэлгээг тооцсон дэд үзүүлэлтүүдээр нарийвчлан харвал 2020 онд судалгаанд оролцсон барилгын салбарын бизнес эрхлэгчдийн 58 хувь нь үйлдвэрлэлийн хэмжээ буурсан, 58 хувь нь захиалгат, төлөвлөгөөт үйлдвэрлэлийн хэмжээ хэвийн түвшингээс бага байсан гэжээ. Барилгын салбарын бизнес эрхлэгчдийн 59 хувь нь борлуулалтын орлогын хэмжээ буурсан гэсэн бол 58 хувь нь санхүүгийн нөхцөл байдал муу байна гэсэн байна. (Зураг 18)

Зураг 18. Барилгын салбарын үйл ажиллагааны нарийвчилсан үнэлгээ




Барилгын салбарын бизнес эрхлэгчдийн хувьд үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд тулгарч буй хүндрэлийг тодруулахад давхардсан тоогоор 57 хувь нь барилгын материал түүхий эдийн үнэ, 44 хувь нь банкнаас зээл авах боломж, 39 хувь нь хүүгийн зардал гэх мэт санхүүтэй холбогдох зардлууд хамгийн их хүндрэл үүсгэж байна гэжээ. (Хүснэгт 4)

Хүснэгт 4. Барилгын салбарын бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд тулгарч буй бэрхшээл

Д/д	Тулгарч буй бэрхшээл	Хувь
1	Барилгын материал, түүхий эдийн үнэ	57%
2	Банкнаас зээл авах боломж	44%
3	Санхүүгийн зардал (хүүгийн зардал г.м)	39%

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагааны үнэлгээ



Хөдөө аж ахуйн салбарт мал аж ахуй, газар тариалан, бусад хөдөө аж ахуйн салбарыг нэгтгэн авч үзсэн.

Хөдөө аж ахуйн салбар нь ДНБ-ний 15 хувь, нийт ажиллагсдын 24 хувийг эзэлдэг Монгол улсын эдийн засгийн суурь салбар юм.

Гол үзүүлэлт	2019 он	2020он	Өөрчлөлт	%
Үйлдвэрлэл (тэрбум.төг, 2010 з.үнэ)	2,537.9	2,694.5	156.6	6.2%
Ажиллагсдын тоо (мян.хүн)	310.02	269.2	-40.8	-13.2%
Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн тоо	3,564	2,996	-568	-16%


Эх үүсвэр: Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд үндэслэн хийсэн судлаачийн тооцоолол

Үндэсний статистикийн хорооны статистик мэдээллийг авч үзвэл 2020 онд салбарын үйлдвэрлэл 2.7 их наяд төгрөг болж өмнөх оноос 6.2 хувиар өссөн бол ажиллагсдын тоо 269.2 мянган болж өмнөх оноос 13.2 хувиар буурсан байна.

2021 оны 1-р улирлын байдлаар нийт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 4 хувь ба 3 мянга орчим аж ахуйн нэгж хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь өмнөх оноос 16 хувиар буурсан байна.


Бизнесийн үйл ажиллагааны үнэлгээг эдийн засгийн салбараар ангилан авч үзвэл хөдөө аж ахуйн салбарт -0.46 ба дундаж индексээс бага үнэлгээ өгсөн байна (Зураг 19).

Зураг 19. Бизнесийн үйл ажиллагааны индекс



Бизнесийн үйл ажиллагааны үнэлгээг тооцсон дэд үзүүлэлтүүдээр нарийвчлан харвал 2020 онд судалгаанд оролцсон хөдөө аж ахуйн салбарын бизнес эрхлэгчдийн 53 хувь нь үйлдвэрлэлийн хэмжээ буурсан, 64 хувь нь хөдөө аж ахуйн гаралтай бараа бүтээгдэхүүний эрэлтийн хэмжээ хэвийн түвшингээс бага байсан гэжээ. Хөдөө аж ахуйн салбарын бизнес эрхлэгчдийн 50 хувь нь борлуулалтын орлогын хэмжээ буурсан гэсэн бол 59 хувь нь санхүүгийн нөхцөл байдал муу байна гэсэн байна. (Зураг 20)

Зураг 20. Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагааны нарийвчилсан үнэлгээ




Хөдөө аж ахуйн салбарын бизнес эрхлэгчдийн хувьд үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд тулгарч буй хүндрэлийг тодруулахад давхардсан тоогоор 50 хувь нь төлбөр гүйцэтгэх чадвар, зээлийн нөхцөл гэх мэт санхүүтэй холбогдох асуудал, 40 хувь нь дотоод бараа, бүтээгдэхүүний эрэлт, 34 хувь нь бизнес эдийн засгийн тодорхойгүй орчин, нөхцөл хамгийн их хүндрэл үүсгэж байна гэжээ. (Хүснэгт 5)

Хүснэгт 5. Хөдөө аж ахуйн салбарын бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд тулгарч буй бэрхшээл

Д/д	Тулгарч буй бэрхшээл	Хувь
1	Санхүүгийн асуудал (төлбөрийн чадваргүй байдал, зээлийн нөхцөл г.м)	50%
2	Дотоодын эрэлт	40%
3	Тодорхой бус бизнес, эдийн засгийн орчин	34%

Үйлчилгээ болон бусад салбарын үйл ажиллагааны үнэлгээ



Гол үзүүлэлт	2019 он	2020он	Өөрчлөлт	%
Үйлдвэрлэл (тэрбум.төг, 2010 з.үнэ)	5,706.3	5,394.3	-312.0	-5.5%
Ажиллагсдын тоо (мян.хүн)	367.5	381.6	14.1	3.8%
Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн тоо	21,712	22,085	373	2%

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд үндэслэн хийсэн судлаачийн тооцоолол

Үйлчилгээ болон бусад бизнесийн үйл ажиллагааны салбарт зочид буудал, нийтийн хоол, тээвэр, мэдээлэл, холбоо, бусад үйлчилгээний салбарыг нэгтгэн авч үзсэн. Үйлчилгээ болон бусад салбар нь ДНБ-ний 30 хувь, нийт ажиллагсдын 34 хувийг эзэлдэг томоохон салбаруудын нэг юм.

Үндэсний статистикийн хорооны статистик мэдээллийг авч үзвэл 2020 онд салбарын үйлдвэрлэл 5.4 их наяд төгрөг болж өмнөх оноос 5.5 хувиар буурсан байна. Ажиллагсдын тоо нь 382 мянга болж өмнөх оноос 3.8 хувиар өссөн.

2021 оны 1-р улирлын байдлаар нийт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 29 хувь ба 22 мянга орчим аж ахуйн нэгж энэ салбарт үйл ажиллагаа явуулж байна.


Бизнесийн үйл ажиллагааны үнэлгээг эдийн засгийн салбараар ангилан авч үзвэл үйлчилгээний салбарт -0.46 ба дундаж индексээс бага үнэлгээ өгсөн байна (Зураг 21).

Зураг 21. Бизнесийн үйл ажиллагааны индекс



Бизнесийн үйл ажиллагааны үнэлгээг дэд үзүүлэлтүүдээр нарийвчлан авч үзвэл 2020 онд судалгаанд оролцсон үйлчилгээний салбарын бизнес эрхлэгчдийн 69 хувь нь үйл ажиллагааны хэмжээ буурсан гэсэн ба бусад салбаруудаас үйл ажиллагааны хэмжээ хамгийн ихээр буурсан гэж хариулжээ. Бараа, үйлчилгээний эрэлтийн хэмжээ хэвийн түвшингээс бага байсан гэж 60 хувь нь хариулсан бол 56 хувь нь орлогын хэмжээ буурсан гэжээ. Мөн үйлчилгээний салбарын судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 58 хувь нь санхүүгийн нөхцөл байдал муу байна гэж хариулжээ. (Зураг 22)

Зураг 22. Үйлчилгээний салбарын үйл ажиллагааны нарийвчилсан үнэлгээ



Үйлчилгээний салбарын бизнес эрхлэгчдийн хувьд үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд тулгарч буй хүндрэлийг тодруулахад давхардсан тоогоор 42 хувь нь эрэлтийн түвшин хангалттай их биш, 36 хувь нь төлбөр гүйцэтгэх чадвар, зээлийн нөхцөл гэх мэт санхүүтэй холбогдох асуудал, 36 хувь нь банкнаас зээл авах боломж бага байгаа нь хамгийн их хүндрэл үүсгэж байна гэжээ. (Хүснэгт 6)

Хүснэгт 6. Үйлчилгээний салбарын бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд тулгарч буй бэрхшээл


Д/д	Үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд тулгарч буй бэрхшээл	Хувь
1	Эрэлт хангалттай биш	42%
2	Санхүүгийн зардал (хүүгийн зардал гм.)	36%
3	Банкнаас зээл авах боломж	36%



## II. Бизнес тугламдаж буй гол асуудлууд

Бизнесийн орчинг сайжруулахад тулгарч буй асуудлыг тодруулахад судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 58 хувь нь зээлийн өндөр хүү, хугацаа, 54 хувь нь бодлогын тогтворгүй байдал, 51 хувь нь татварын хувь хэмжээ гэсэн асуудлуудыг хамгийн их саад болж буй нэн тэргүүнд шийдвэрлэх асуудлуудаар нэрлэсэн байна. (Зураг 23)

Зураг 23. Бизнесийн орчинг сайжруулахад нэн тэргүүнд шийдвэрлэх асуудлууд



Бизнесийн орчинд нэн тэргүүнд шийдвэрлэх асуудлыг сүүлийн 4 жилээр нэгтгэн авч үзвэл “Зээлийн өндөр хүү, хугацаа” гэсэн асуудлыг дараалан хамгийн тулгамдаж буй асуудлаар нэрлэсэн байна. Түүнчлэн бизнестэй холбогдох “Бодлогын тогтворгүй байдал” нь бизнесийн орчинг сайжруулахад нэн тэргүүнд шийдвэрлэх хэрэгтэй асуудал гэж хариулжээ. (Хүснэгт 7)


Хүснэгт 7. Бизнесийн орчинг сайжруулахад тулгамдаж байгаа гол асуудлууд (2017-2020 он)

Эрэмбэ	2017	2018	2019	2020
1	Зээлийн өндөр хүү/ богино хугацаа	Зээлийн өндөр хүү/ хугацаа	Зээлийн хүү, хугацаа	Зээлийн өндөр хүү, хугацаа
2	Бодлогын тогтворгүй байдал	Бодлогын тогтворгүй байдал	Авилгал, хээл хахууль	Бодлогын тогтворгүй байдал
3	Татварын хувь, хэмжээ (ААНОАТ, НӨАТ г.м)	Авилга, хээл хахууль	Бодлогын тогтворгүй байдал	Татварын хувь, хэмжээ (ААНОАТ, НӨАТ г.м)
4	Хариуцлагагүй, хууль хэрэгждэггүй байдал	Татварын хувь, хэмжээ (ААНОАТ, НӨАТ г.м)	Хүнд суртал	Авлига, хээл хахууль
5	Авилга, хээл хахууль	Хүнд суртал	Татварын хувь, хэмжээ (ААНОАТ, НӨАТ г.м)	Хүнд суртал
6	Төрийн албаны нүсэр бүтэц	Хариуцлагагүй, хууль хэрэгждэггүй байдал	Хуулийн хэрэгжилт хангалтгүй	Хариуцлагагүй, хууль хэрэгждэггүй байдал
7	Хүнд суртал	Төрийн нүсэр бүтэц	Шударга бус тендер шалгаруулалт	Шударга бус тендер шалгаруулалт

## Бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд тулгардаг бэрхшээл

Бизнесээ өргөжүүлэхэд тулгарч буй бэрхшээлийг тухайн бизнесийн салбар бүрт тулгардаг нийтлэг хүндрэлээр нь асуусан бөгөөд, үр дүнг нэгтгэн авч үзвэл үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарт төлбөр гүйцэтгэх чадвар, зээлийн нөхцөл г.м санхүүтэй холбогдох асуудал, дотоод эрэлт хамгийн хүндрэл үүсгэж байна гэжээ. Харин үйлчилгээ, худалдааны салбаруудын хувьд зээл авах боломж, эрэлт, борлуулалтын хэмжээ, хүүгийн зардал гэх мэт санхүүтэй холбогдох зардлууд хамгийн хүндрэлтэй байна. Барилгын салбарын хувьд түүхий эд материалын үнэ хамгийн их хүндрэл үүсгэж байна гэж хариулсан байна. Мөн үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбаруудын хувьд дээрх салбаруудад дурдсан хүндрэлийг мөн дурдсан бөгөөд мөн тодорхой бус бизнес, эдийн засгийн орчин, бизнестэй холбогдох ойлгомжгүй уялдаа холбоогүй хууль, тогтоомжууд хүндрэл үүсгэдэг гэжээ. (Зураг 25).

Зураг 25. Бизнесээ өргөжүүлэхэд тулгарч буй гол бэрхшээл, салбараар



### III. Судалгааны арга зүй, оролцогчдын мэдээлэл


МҮХАҮТ-аас Бизнес итгэлийн индекс судалгааг 2000 оноос эхлэн явуулж байгаа бөгөөд 2020 оны судалгааг Европын холбоо, OECD-н бизнесийн итгэлийн индекс, бизнесийн хандлагын судалгаануудын аргачлалыг судлан эдийн засгийн үндсэн салбаруудаар аргачлалыг шинэчлэн боловсруулав.

Бизнесийн ерөнхий орчны үнэлгээ, бизнесийн үйл ажиллагааны үнэлгээ, хөрөнгө оруулалтын орчны үнэлгээ, макро эдийн засгийн үзүүлэлтүүд гэсэн 4 дэд үзүүлэлтүүдээр итгэлийн индексийг тооцсон. Шинэчилсэн аргачлалаар бизнесийн үйл ажиллагаатай холбогдох үзүүлэлтийг өмнөх жилүүдэд зөвхөн ашиг, орлогын өөрчлөлтөөр хэмждэг байсан бол 2020 оноос эхлэн үйл ажиллагааны хэмжээ, эрэлтийн хэмжээ, хүчин чадлын хэмжээ, санхүүгийн нөхцөл байдал зэрэг үзүүлэлтүүдийг нэмж тооцох болсон.


Судалгааг 2021 оны 3-4 сард Улаанбаатар хот, орон нутгийн бизнес эрхлэгчдийн дунд цахим асуулгын хэлбэрээр явуулж нийт 1456 аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийг хамруулав.

Судалгаанд оролцогчдын түүврийг сонгохдоо аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн үндсэн салбаруудаар түүврийг жигд тархаах зорилгоор нийт үйл ажиллагаа идэвхтэй явуулж байгаа аж ахуйн нэгжийн тоог салбаруудаар ангилан, түүврийг тооцоолон зорилтот салбарын бизнес эрхлэгчдээс авсан болно.

Судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 15 хувь нь үйлдвэрлэл, 25 хувь нь худалдаа, 14 хувь нь барилга, 10 хувь нь ХАА, 37 хувь нь үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг байна. Борлуулалтын орлогын түвшингээр авч үзвэл 57 хувь нь 300 сая төгрөг хүртэл жилийн орлоготой, 25 хувь нь 301 саяас 1 тэрбум хүртэл төгрөгийн орлоготой, 19 хувь нь нэг тэрбумаас дээш орлоготой байна. Ажиллагсдын тооны хувьд 66 хувь нь 19 хүртэл, 31 хувь нь 20-199, 3 хувь нь 200-аас дээш байна. Мөн бизнесийн насжилтын хувьд 40 хувь нь 10-с дээш жил, 27 хувь нь 5-10 жил үйл ажиллагаа тасралтгүй явуулж байгаа аж ахуйн нэгжүүд хамрагдсан байна.







Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим  
МҮХАҮТ-ын байр, М.Гандигийн гудамж, 15-р хороо, Хан-Уул дүүрэг,  
Улаанбаатар хот 17011, UB Post – 1010011001  
Утас: 77277070, Факс: (+976) 11324620



[www.mongolchamber.mn](http://www.mongolchamber.mn)



[policy@mongolchamber.mn](mailto:policy@mongolchamber.mn)



Энэхүү хэвлэлийн агуулгыг Зөвлөх Компани бүрэн хариуцах ба Европын Холбооны үзэл санааг ямар нэгэн байдлаар тусгаагүй болно.